



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

**Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх
вакцинжуулалтын арга хэмжээг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/179 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/981 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2023 оны 08 дугаар сарын 10-ний өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад дүүргийн өвчинд мэдрэмтгий 2424 хурга, 1776 ишгийг бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ трейд" ХХК (А.Цэрэндагва)-д, 1 дүгээр хороо (Н.Нямзав), 2 дугаар хороо (Б.Батзориг)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зүү тариур халдвар хамгаалал, хөдөлмөр хамгаалал, шатах тослох материал, ажиллах хүн хүчний зардлыг хавсралтаар баталсугай.

4. Мал, амьтны бруцеллөз өвчний дархлаажуулалтад шаардагдах 361,500 (Гурван зуун жаран нэгэн мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Я.Батсүх) -т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 09 дүгээр сарын 04 ны өдрийн
10.1.27 дугаар захирамжийн хавсралт



**БРУЦЕЛЛЭЗ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТ
БОЛОН ХЯНАЛТЫН АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	120	2410	289,200
2	Шатахуун А-92 (вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад)	л	30	2410	72,300
Нийт дүн					361,500